

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын "Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг" гэснийг "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.9-д заасныг" гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн "мөрдөнө" гэснийг "мөрдөж болно" гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "тоон гарын үсгээр" гэснийг "цахим гарын үсэг, эсхүл давтагдашгүй дугаараар" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР